

Вакцин гэдэг нь халдварт өвчин үүсгэгч бичил биетний хоруу чанарыг сулруулах эсвэл уг бичил биетэнг үхүүлж дархлал тогтоох чадварыг нь хадгалан гаргаж авсан хими биологийн идэвхт бэлдмэлийг хэлнэ.

Вакциныг үндсэн гурван бүлэгт ангилдаг.

1. Амьд вакцин:

-Халдварт өвчин үүсгэгч бичил биетний хоруу чанарыг сулруулж бэлтгэсэн вакциныг хэлнэ. Үүнд: халдварт саа, улаан бурхан, сүрьеэ, гахайн хавдраас сэргийлэх вакцинүүд орно.

2. Үхүүлсэн вакцин:

-Халдварт өвчин үүсгэгч бичил биетний дархлал тогтоох чанарыг хэвээр хадгалж уг бичил биетнийг хими, физикийн нөлөөгөөр үхүүлж бэлтгэсэн вакциныг хэлнэ. Үүнд: сахуу-хөхүүл ханиад-татрангаас сэргийлэх вакцин орно.

3. Химийн вакцин:

– Химийн янз бүрийн аргаар микробын эсийн бүрэлдэхүүн хэсгийг салган авч бэлдэнэ.

Дархлаажуулалт

Идэвхтэй дархлаа үүсгэх зорилгоор хэрэглэдэг эсрэгтөрөгч, эсрэгтөрөгчийн холимогийг вакцинтарилга буюу иммуноген гэж нэрлэх ба ийм замаар дархлааны хариу урвал үүсэх процессыг дархлаажуулалт гэнэ.

Дархлаажуулалтын хэлбэр

Заавал хийх дархлаажуулалт: Энэ нь дархлаажуулах насны бүх хүнийг заавал хамарвал зохих дархлаажуулалтыг хэлнэ.

Нөхөн хийх дархлаажуулалт: Энэ нь заавал хийх дархлаажуулалтын анхны болон давтан тунгаас хоцорсон хүнд дархлаажуулах бэлдмэл хэрэглэхийг;

Нэмэлтээр хийх дархлаажуулалт: "Нэмэлт дархлаажуулалт" гэж хүн амын дархлалын ерөнхий түвшин буурахаас сэргийлж, урьд нь заавал хийх дархлаажуулалтад хамрагдсан эсэхийг үл харгалзан дархлаажуулах бэлдмэл хэрэглэхийг;

Сайн дурын дархлаажуулалт: "сайн дурын дархлаажуулалт" гэж иргэн өөрийн хүсэлтээр дархлаажуулах бэлдмэл хэрэглэхийг;

Товлолын дархлаажуулалтын тухай

“Дархлаажуулалтын үндэсний товлал” гэж улс орны хэмжээнд заавал хийх дархлаажуулалтад хамрагдах хүүхдийн нас, цаг хугацааны товыг хэлнэ.

Манай улсад заавал хийгдэх дархлаажуулалтыг хүн амд үнэ төлбөргүйгээр явуулдаг ба дархлаажуулалтын үндэсний товлалын дагуу хийдэг байна. Заавал хийгдэх дархлаажуулалтад 10 гаруй өвчнөөс сэргийлэх 6 төрлийн вакцин багтдаг.

Сүрьеэ,

Халдварт саа,

Гепатит В,

Сахуу,

Хөхүүл ханиад,

Татран,

Хемопелиус инфлюенза,

Улаанбурхан,

Гахай хавдар,

Улаанууд зэрэг өвчнөөс сэргийлэх вакцинууд орно.